

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

Агуулга.....	1
1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3. Менежментийн захидал.....	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк
ЗГ	Засгийн газар
ТХН	Төсөл хэрэгжүүлэгч нэгж
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ДАРХАН ХОТЫН БОХИР УСНЫ
МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Ч.БАТЗОРИГ ТАНАА

2020.04.30 № 06/1449
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төслийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч Ч. Батзориг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн заавар, аргачлалд нийцсэн санхүүгийн программ хангамж ашиглах, Шилэн дансны тухай хуулийг дагаж мөрдөх талаарх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 25-наас 2020 оны 04 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Далайван Аудит ХХК-ийн захирал Ц.Жигдэн хянан удирдаж, чанарын хяналтын менежер М.Болормаа, аудитор Ц.Ганболд, аудиторовын туслах Э.Төгөлдөр нар хэрэгжүүлэв.

Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 25/20 дугаар бүхий албан бичгээр хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. Далайван Аудит ХХК нь 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 87/20 тоот албан бичгээр төлсийн нэгжийн санхүүгийн тайланг хүлээн авч аудитын ажлыг эхлүүлсэн.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Засгийн газар, Азийн Хөгжлийн Банк хооронд 2015 оны 06 дугаар сарын 5-ны өдөр байгуулсан зээлийн хэлэлцээрээр “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах зээлийн төсөл”-ийг хэрэгжүүлэхэд АХБ-ны ердийн хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжигдэх 9,450,000 ам.долларын зээл болон АХБ-ны Азийн хөгжлийн сангийн тусгай сангийн эх үүсвэрээс санхүүжигдэх 6,159,000 зээлжих тусгай эрхтэй тэнцэх 9,050,000 ам.долларын зээлийг олгохоор болсон. Зээлийн хэлэлцээр тус бүр нь 2015 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.

АХБ-ны зээлийн хөрөнгийн ашиглалтын нөхцөлд тусгагдсаны дагуу Дамжуулан зээлдэх гэрээг Сангийн яам болон Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар хооронд 2016 оны 03 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан.

Төсөл хаах хугацаа 2019 оны 06 дугаар сарын 30-ны өдөр байсан бөгөөд 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн гэрээний өөрчлөлтөөр төсөл хаах хугацааг 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр болгосон.

Төслийн зорилго нь:

- Дархан-Уул аймгийн хот байгуулалт түүний төлөвлөлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүй, ээлтэй, тогтвортой байдлаар хөгжүүлснээр чанар аюулгүй байдлын үзүүлэлтийн түвшин дээшлүүлж, хүн амын амьдрах орчны төлөв байдал сайжруулах,
- Монгол Улсын 2 дахь том хотод үйлдвэржилтийг дэмжих, төвлөрлийг сааруулах, хот хөдөөгийн ялгааг арилгах үндсэн нөхцлийг бий болгох,
- Дархан хотын бохир усны менежмент сайжирч, бохир ус цэвэрлэх төв байгууламж, ариутгах татуурга болон насос станцын үйл ажиллагааны түвшин дээшлүүлэх, Дарханы ус сувгийн байгууллагын менежментийн чадавхыг бэхжүүлүүлэх, байгууллагын бодлого бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгоход дэмжлэг үзүүлэх, мөн Дархан хотын нийтийн аж ахуйн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, бүтцийг оновчтой боловсронгуй болгох үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглүүлэн техникийн туслалцааг үзүүлэх зэрэг зориготой байна.

Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төслийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Монгол Улсын Засгийн газраас Азийн хөгжлийн банктай байгуулсан гэрээ хэлцэл болон Сангийн сайдын баталсан 2015 оны 196 дугаар тогтоолоор баталсан чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд Дархан-Уул амгийн бохир ус, цэвэрлэх байгууламж, ариутгах татуурга болон насос станцын үйл ажиллагааны түвшинг дээшлүүлэх, Дархан Ус Суваг ХК-ийн менежментийн чадавхийг бэхжүүлж, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгоход дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд техникийн туслалцаа үзүүлэх гэж тодорхойлжээ.

Дархан хотын бохир усны цэвэрлэх байгууламж, насос станцуудын шинэчлэлийн ажлын хүрээнд цэвэрлэх байгууламжийг шинээр барих, тоног төхөөрөмжийг угсарч суурилуулах ажлын гүйцэтгэл угсралтын үе шатандаа хэрэгжиж байна. Тайлант хугацаанд ф300, 410мм голчтой хуванцар хоолой шинээр угсрах, ариутгах татуургын 52 ш төмөр бетон худгийн угсралт, 400 метрийн урттай явган хүний бетонон замын ажлыг графикт хугацаанд хийж шугам хоолойн туршилт болон нөхөн сэргээлтийн ажлуудыг хийж дууссан байна. Мөн техникийн шаардлага хангасан экскаваторыг худалдан авч хүлээн авагч байгууллагад хүлээлгэн өгсөн байна.

Төслийн менежментийн дэмжлэг ба чадавхыг бэхжүүлэх ажлын хүрээнд сургалт зохион байгуулах, тоног төхөөрөмжийн суурилалтууд дээр хяналт тавих, заавар зөвлөгөө өгөх зэрэг ажлуудыг зохион байгуулж ажилласан байна.

Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл нь 2018 онд санхүүгийн тайлангаа Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газарт өгч орон нутгийн төсвийн багцад нэгтүүлсэн.

Улсын Их Хурлаас Монгол Улсын 2019 оны жилийн төсвийг боловсруулахдаа Засгийн газрын шугамаар хэрэгжиж байгаа зээл, тусламжийн бүх төсөл хөтөлбөрүүд Сангийн сайдын багцад шилжүүлэн баталсан. Үүнтэй холбоотойгоор төсөл нь 2018 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон хаалтын тайлангаа Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газарт өгч Сангийн яаманд балансын тэг үлдэгдэлтэй шилжсэн.

Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төслийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”
- Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаалаар батлагдсан “Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүн болох Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”
- Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”.

Тайлант хугацаанд компанийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон;

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Төсөл нь өөрийн үйл ажиллагаанд тохирсон нягтлан бодох бүртгэлийн бүртгэлийн бодлогын баримт бичгийг дагаж мөрддөг.

Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Инфосистемс” ХХК-ийн “Пакс” программ хангамж ашиглаж байна.

Дархан хотын бохир усны менежментийн төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

Төсөл нь төлөвлөсөн үйл ажиллагааг тогтоосон хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэх, зээлийн хөрөнгийг зорилгын хүрээнд үр ашигтай зарцуулах, хэрэгжилтэд хяналт тавих, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, ил тод байдлыг хангахын тулд төслийн гүйцэтгэлийн хяналт, санхүүгийн хяналт, худалдан авах үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлдэг. АХБ болон төслийн гүйцэтгэгч байгууллагаас төслийн үйл ажиллагааны үе шат бүрт хяналт тавьж ажилладаг.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын гүйцэтгэлийн үе шатанд 2 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төслийн үйл ажиллагаанд зориулсан төлбөрүүдийг төлөхдөө гүйцэтгэгч болон АХБ-наас хяналт хийгэж зөвшөөрөгдсөн зардлуудыг санхүүжүүлдэг тул санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнгээс тооцох нь илүү бодитой гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 26,159,002.1 мянган төгрөгөөс 523,180.0 мянган төгрөгөөр тооцон материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөөгүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төслийн 2019 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,407,374.7 мянган төгрөгөөр буюу 166.04 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, урьдчилж гарсан зардал, дуусаагүй барилга, урт хугацаат өр төлбөр, хуримтлагдсан үр дүн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /мянган төгрөг/
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,005,842.1	7,334,950.4	2,329,108.3
Урьдчилж гарсан зардал	-	1,673,325.6	1,673,325.6
Үндсэн хөрөнгө	197,708.6	197,708.6	0.0
Хуримтлагдсан элэгдэл	(90,306.9)	(123,164.7)	-32,857.8
Биет бус хөрөнгө	5,060.0	5,060.0	0.0
Хуримтлагдсан элэгдэл	(3,263.7)	(4,528.7)	-1,265.0
Дуусаагүй барилга	10,639,384.1	17,075,650.9	6,436,266.8
Нийт хөрөнгө	15,754,424.2	26,159,002.1	10,404,577.9
Богино хугацаат өр төлбөр	-	1,432,873.1	1,432,873.1
Урт хугацаат өр төлбөр	-	34,112,858.2	34,112,858.2
Засгийн газрын оруулсан капитал / засгийн газрын сан, орон нутгийн сан/	2,796.8	7,423.6	4,626.8
Хуримтлагдсан үр дүн	15,751,627.4	(9,394,152.8)	-25,145,780.2
Өмнөх оны үр дүн	5,695,157.2	(4,539,629.0)	-10,234,786.2
Тайлант оны үр дүн	10,056,470.2	(4,854,523.8)	-14,910,994.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	15,754,424.2	26,159,002.1	10,404,577.9

Мөнгөн хөрөнгө: Төсөл нь тайлант хугацааны эцэст ам.долларын дансны үлдэгдэл 7,304,140.5 мянган төгрөг, төгрөгийн дансдын үлдэгдэл 30,809.9 мянган төгрөгийг тайлагнасан.

Урьдчилж гарсан зардал: Дархан хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, насос станц болон 12 сарын зүгшрүүлэлтийн дэмжлэг үзүүлэлт гэрээний дагуу гүйцэтгэгч компанид олгосон 689,437.0 ам.доллар буюу 1,673,325.6 мянган төгрөгийг урьдчилж гарсан зардлаар тайлагнасан.

Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө: Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр төслийн нэгжийн үйл ажиллагаанд зориулан худалдан авсан тээврийн хэрэгсэл, компьютер, тавилга эд хогшлыг үндсэн хөрөнгөөр, санхүүгийн программ хангамжийг биет бус хөрөнгөөр тус тус бүртгэсэн.Тайлант хугацаанд үндсэн хөрөнгөд 34,122.8 мянган төгрөгийн элэгдэл байгуулж зардлаар бүртгэсэн.

Дуусаагүй барилга: Төслийн хүрээнд Дархан хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, насос станцын барилгын ажлын зардал нийт 17,075,650.9 мянган төгрөгийг дуусаагүй барилга дансанд хуримтлуулан бүртгэсэн.

Богино хугацаат өр төлбөр: Дархан хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, насос станцын барилгын ажлыг гүйцэтгэгч компанийн ирүүлсэн гүйцэтгэлээс 524,186.08 ам.доллар буюу 1,432,873.1 мянган төгрөгийн барьцаа төлбөрийг богино хугацаат өр төлбөрөөр тайлагнасан.

Урт хугацаат өр төлбөр: Сангийн сайдын 2011 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 244 дугаар тушаалын дагуу АХБ-наас авсан дамжуулан зээлдүүлэх нөхцөлтэй зээлийн санхүүжилт 34,112,858.2 мянган төгрөгийг урт хугацаат өр төлбөрөөр бүртгэсэн.

Засгийн газрын оруулсан капитал: Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр 253 тоот тушаал, Төрийн өмчийн хорооны 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 3/3374 тоотоор 7,423.6 мянган төгрөг буюу 3,720.16 ам.долларын үндсэн хөрөнгийг засгийн газрын оруулсан капиталар бүртгэсэн.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг санхүүжүүлэхэд зориулан тайлант онд 10,225,000.0 мянган төгрөгийн хөрөнгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 12,338,474.7 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авсан.

Төсвийн зардлын гүйцэтгэл 10,219,651.4 мянган төгрөг буюу 99.95 хувьтай байна. Үүнд төслийн нэгжийн үйл ажиллагааны зардал 5,348.6 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь нөлөөлжээ.

Хүснэгт 2. Төслийн орлого / мянган төгрөг/

Санхүүжилтийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	10,225,000.0	12,338,474.7	-2,113,474.7	120.67
Нийт дүн	10,225,000.0	12,338,474.7	-2,113,474.7	120.67

Хүснэгт 3. Төсвийн зардал / мянган төгрөг/

Санхүүжилтийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Хөрөнгийн зардал	10,225,000.0	10,219,651.4	5,348.6	99.95
Нийт дүн	10,225,000.0	10,219,651.4	5,348.6	99.95

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан төсвийн хүрээнд зүй зохистой зарцуулсан.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 2 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 4 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 211,264.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 211,264.2 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Аудитын явцад санхүүгийн тайланд дараах залруулгыг хийв. Үүнд:

Урьдчилж төлсөн 689,437.00 ам.долларын үлдэгдэлд ханшийн тэгшитгэл тооцож урьдчилж төлсөн зардал дансыг 211,264.2 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн нь “тодруулга ба толилуулга”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна, НББОУС21 “Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 2 дугаар бүлэг “5.1.4.үнэн зөв байх,” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар дор дурьдсан асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай. Үүнд:

- Төслийн хаалтын хугацаа 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр тул төслийн үйл ажиллагаа, зээлийн гэрээний хэрэгжилтийг хянах;
- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд шаардсан мэдээллийг бүрэн оруулсан эсэхийг хянах;
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө болон төсвийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг эдийн засгийн ангиллаар нь задалж тайлагнаж байгаа эсэхийг хянах;
- Төсвийн тухай хуульд олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх төслийн нэгж нь төсвийн байгууллага байхаар зааснаар нягтлан бодох бүртгэлээ УСНББОУС-ын дагуу бүрэн аккруэл сууриар бүртгэхтэй холбоотойгоор олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд тохирсон нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын нэгдсэн заавар, аргачлалыг Сангийн Яамнаас тусгайлан гаргах хэрэгтэй байна. Уг заавар, аргачлалд төслийн нэгж нь АХБ-ны зарцуулалтын үндсэн процедур болох шууд төлбөр, урьдчилгаа төлбөр, нөхөн дүүргэлтийг аккруэль сууриар хэрхэн хүлээн зөвшөөрч бүртгэж, тайлагнах, хүлээн авсан болон зарцуулсан санхүүжилтэнд гадаад валютын ханшийг хэрхэн ашиглах, төслийн санхүүжилтээр бий болсон биет болон биет бус хөрөнгийг элэгдүүлэх хугацаа болон аргыг заах, төслийн санхүүжилтээр баригдаж байгаа барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг хэрхэн хуримтлуулан бүртгэх, хөрөнгийг төсөл дуусахад төрийн өмчид шилжүүлэх, зээл тусламжийг төслийн нягтлан бодох бүртгэлд өр төлбөрөөр тусгах эсэх, зээлийн хүүгийн өр төлбөрийг хэрхэн бүртгэх;

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу нийт 147 мэдээлэл оруулахаас 131 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1.900.0 мянган төгрөгийн зөрчилд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төслийн 2019 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Санхүүгийн программ хангамжийн талаар

3.1.1 Илрүүлэлт:

Төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Инфосистемс” ХХК-ийн “Пакс” санхүүгийн программ хангамж ашигладаг. Тус программ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, УСНББОУС-д нийцээгүй, харин АХБ-ны Зарцуулалалтын журмын дагуу мөнгөн сууриар нягтлан бодох бүртгэл хөтлөхөөр тохируулга хийгдсэн байна.

Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байх, тодруулга ба толилуулга, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйлийн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Төслийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал буруу, алдаатай бэлтгэгдэх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төслийн санхүүгийн программыг Нягтлан бодох бүртгэлийн хууль УСНББОУС-ын шаардлагад нийцүүлсэн байдлаар шинэчлэх, холбогдох өөрчлөлтийг оруулах.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төслийн санхүүгийн программыг шинэчлэх зардлын төсөв баталж өгсөн үед “Инфосистемс” ХХК-д хандан холбогдох өөрчлөлтийг хийлгэж зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Шилэн дансны мэдээллийн талаар

3.2.1 Илрүүлэлт:

Төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу нийт 147 мэдээлэл оруулахаас 131 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

3.2.2 Эрсдэл:

Шилэн дансны тухай хууль зөрчих, мэдээлэл буруу орох,

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу мэдээллийг тогтсон хугацаанд нь бүрэн гүйцэт оруулах.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Шилэн дансанд систем алдаа зааж ашиглах боломжгүй байдалтай байснаас хамаарч 1 болон 8 дугаар саруудад холбогдох 16 мэдээлэлийг хугацаа хоцорч оруулсан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,005,842,166.38	9,008,276,048.80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,005,842,166.38	7,334,950,400.47
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	5,005,842,166.38	7,334,950,400.47
31210	Төгрөг	59,411,212.18	30,809,878.51
31211	Төрийн сангийн харилцах	-	30,809,878.51
31213	Арилжааны банк дахь харилцах	59,411,212.18	
31220	Гадаад валют	4,946,430,954.20	7,304,140,521.96
31223	Арилжааны банк дахь харилцах	4,946,430,954.20	7,304,140,521.96
34	УРЬДЧИЛГАА	-	1,673,325,648.33
34600	Урьдчилж гарсан зардал	-	1,673,325,648.33
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,748,582,054.74	17,150,726,074.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,748,582,054.74	17,150,726,074.86
39200	Биет хөрөнгө	10,746,785,754.74	17,150,194,774.86
39203	Авто-тээврийн хэрэгсэл	143,000,000.00	143,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(61,489,999.99)	(85,323,333.32)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	38,307,786.80	38,307,786.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(19,766,817.99)	(27,428,375.35)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,400,711.68	16,400,711.68
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,050,030.87)	(10,412,946.04)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	10,639,384,105.11	17,075,650,931.09
39300	Биет бус хөрөнгө	1,796,300.00	531,300.00
39301	Програм хангамж	5,060,000.00	5,060,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,263,700.00)	(4,528,700.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	15,754,424,221.12	26,159,002,123.66
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	35,545,731,306.92
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,432,873,133.40
41300	Өглөг	-	1,432,873,133.40
41360	Бусад өглөг	-	1,432,873,133.40
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,432,873,133.40
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	34,112,858,173.52
42200	Урт хугацаат зээл	-	34,112,858,173.52
42220	Гадаад валют	-	34,112,858,173.52
42222	Олон улсын санхүүгийн байгууллагаас	-	34,112,858,173.52
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	15,754,424,221.12	(9,386,729,183.26)
51	Засгийн газрын хувь оролцоо	15,754,424,221.12	(9,386,729,183.26)
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,796,759.92	7,423,611.68
51200	Хуримтлагдсан үр дүн	15,751,627,461.20	(9,394,152,794.94)
51210	Өмнөх үеийн үр дүн	5,695,157,221.49	(4,539,629,016.19)
51220	Тайлант үеийн үр дүн	10,056,470,239.71	(4,854,523,778.75)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	15,754,424,221.12	26,159,002,123.66

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	13,053,536,653.09	1,305,327,519.25
11	ТАТВАРЫН ОРЛОГО	579,421,162.19	-
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	579,421,162.19	-
114001	Дотоодын барааны НӨАТ	463,275,623.81	-
114002	Импортын барааны НӨАТ	116,145,538.38	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,474,115,490.90	1,305,327,519.25
120	Нийтлэг татварын бус орлого	12,474,115,490.90	1,305,327,519.25
120002	Хүүгийн орлого	59,770,428.68	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,411,068,226.12	1,304,752,899.28
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,304,752,899.28
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	12,411,068,226.12	-
120009	Бусад орлого	3,276,836.10	574,619.97
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,026,087,247.63	307,597,487.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,026,087,247.63	307,597,487.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,026,087,247.63	307,597,487.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	396,539,311.48	
210101	Үндсэн цалин	396,539,311.48	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,367,017.37	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,112,000.00	
210304	Байрны түрээс	35,112,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	19,987,942.92	
210401	Бичиг хэрэг	4,415,775.28	
210402	Тээвэр, шатахуун	9,980,691.19	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,163,613.71	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,427,862.74	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,869,767.26	
210604	Урсгал засвар	3,869,767.26	
2107	Томилолт, зочны зардал	9,755,000.00	
210702	Дотоод албан томилолт	9,755,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,123,595,492.42	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,114,970,300.27	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,200,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,234,545.45	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	190,646.70	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	209,860,746.38	307,597,487.86

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	175,460,784.52	273,474,682.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	34,399,961.86	34,122,805.86
211	ХҮҮ	180,999,969.80	
2111	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	180,999,969.80	
211101	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	180,999,969.80	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	11,027,449,405.46	997,730,031.39
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	970,979,165.75	5,852,253,810.14
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	970,979,165.75	950,044,918.03
230001	Хаагдсан данс		4,902,208,892.11
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	10,056,470,239.71	(4,854,523,778.75)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	11,044,691,211.31	10,691,747,460.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,044,691,211.31	10,691,747,460.38
120	Нийтлэг татварын бус орлого	11,044,691,211.31	10,691,747,460.38
120002	Хүүгийн орлого	59,770,428.68	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,981,643,946.53	10,691,172,840.38
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	134,867,732.54
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	10,981,643,946.53	5,550,462,941.49
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	0	5,005,842,166.38
120009	Бусад орлого	3,276,836.10	574,619.97
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,636,862,201.05	137,642,220.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,636,862,201.05	137,642,220.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,636,862,201.05	2,774,488.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	396,539,311.48	
210101	Үндсэн цалин	396,539,311.48	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,367,017.37	
210201	Тэтгэврийн даатгал	31,723,144.92	
210202	Тэтгэмжийн даатгал	3,965,393.11	
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,172,314.49	
210204	Ажилгүйдлийн даатгал	793,078.62	
210205	Эрүүл мэндийн даатгал	6,713,086.23	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,112,000.00	
210304	Байрны түрээс	35,112,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	19,987,942.92	
210401	Бичиг хэрэг	4,415,775.28	
210402	Тээвэр, шатахуун	9,980,691.19	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,163,613.71	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,427,862.74	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,869,767.26	

210604	Урсгал засвар	3,869,767.26	
2107	Томилолт, зочны зардал	9,755,000.00	
210702	Дотоод албан томилолт	9,755,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,123,595,492.42	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,114,970,300.27	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,200,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,234,545.45	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	190,646.70	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,635,669.60	2,774,488.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,635,669.60	2,774,488.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0	134,867,732.54
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0	134,867,732.54
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	0	134,867,732.54
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	9,407,829,010.26	10,554,105,239.54
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	6,137,412,740.18	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,137,412,740.18	
2260	Гадаад эх үүсвэрээр	6,137,412,740.18	
226001	Гадаад эх үүсвэрээр	6,137,412,740.18	
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(6,137,412,740.18)	
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	277,445,144.05	(3,219,154,839.07)
14	Бусад эх үүсвэр	0	212,484,779.77
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0	212,484,779.77
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0	3,431,639,618.84
230001	Эргэж төлөгдөх зээл	0	3,431,639,618.84
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	277,445,144.05	
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	277,445,144.05	
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,547,861,414.13	7,334,950,400.47
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,457,980,752.25	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,005,842,166.38	7,334,950,400.47

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2017 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	2,796,759.92	-	5,695,157,221.49	5,697,953,981.41
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,796,759.92	-	5,695,157,221.49	5,697,953,981.41
4	Тайлант үеийн үр дүн	-	-	10,056,470,239.71	10,056,470,239.71
5	2018 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	2,796,759.92	-	15,751,627,461.20	15,754,424,221.12
6	2019 оны 1 дүгээр сарын 1-нээрх үлдэгдэл	2,796,759.92	-	15,751,627,461.20	15,754,424,221.12
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	4,626,851.76	-	(20,291,256,477.39)	(20,286,629,625.63)
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,423,611.68	-	(4,539,629,016.19)	(4,532,205,404.51)
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(4,854,523,778.75)	(4,854,523,778.75)
10	2019 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	7,423,611.68	-	(9,394,152,794.94)	(9,386,729,183.26)

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,225,000,000.00	10,219,651,375.15	5,348,624.85	99.95
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,225,000,000.00	-	10,225,000,000.00	0.00
220001	Барилга байгууламж	10,225,000,000.00	-	10,225,000,000.00	0.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	10,219,651,375.15	(10,219,651,375.15)	100.00
230001	Эргэж төлөгдөх зээл	-	10,219,651,375.15	(10,219,651,375.15)	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,225,000,000.00	12,338,474,697.80	(2,113,474,697.80)	120.67
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,225,000,000.00	12,338,474,697.80	(2,113,474,697.80)	120.67
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	10,225,000,000.00	12,338,474,697.80	(2,113,474,697.80)	120.67
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	7,124,665,489.03	(7,124,665,489.03)	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	-	-	-	-
650010	Гэрээт ажилтан	10	10	-	-

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.04.27	Аудитын нэр: Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: САГ-2020/729/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл	Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгө н дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Инфосистемс” ХХК-ийн “Пакс” санхүүгийн программ хангамж ашигладаг. Тус программ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, УСНББОУС-д нийцээгүй, харин АХБ-ны Зарцуулалалтын журмын дагуу мөнгөн сууриар нягтлан бодох бүртгэл хөтлөхөөр тохируулга хийгдсэн байна. Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байх, тодруулга ба толилуулга, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйлийн заалттай нийцэхгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч	Ч. Батзориг
2	Төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу нийт 147 мэдээлэл оруулахаас 131 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	-	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч	Ч. Батзориг
	Зөвлөмжийн дүн	-			

ТЭМДЭГЛЭЛ

A series of 30 horizontal dotted lines for writing the summary.

